

**Татварын албаны Шилэн дансны хуулийн 2016 оны хэрэгжилтэнд хийсэн
дотоод аудит**

Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад харьяалагдах байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд аудит хийх нэгдсэн удирдамж”, ТЕГ-ын даргын баталсан 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн Дотоод аудит хийх удирдамж, ТЕГ-ын ДААХН-ийн даргын 2017 оны 3 дугаар сарын 7-нд баталсан Дотоод аудит хийх төлөвлөгөөний дагуу ТЕГ-ын Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс, харьяа татварын 32 нэгжүүдийн Шилэн дансны тухай хуулийн 2016 оны хэрэгжилтэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 2017 оны 3 дугаар сарын 07-ноос 3 дугаар сарын 14-ний өдрүүдэд дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Засгийн Газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хүрээнд Татварын албад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээ, тайлангаа дараахь байдлаар байршуулсан байна

/Хүснэгт-1/

/д	Татварын алба	Төсөв гүйцэтгэл			Хөрөнгө оруулалт			Бусад			Нийт		
		Байршуулах мэдээллийн тоо	Байршуулсан тэдээлийн тоо	Хувь	Байршуулах мэдээллийн тоо	Байршуулсан тэдээлийн тоо	Хувь	Байршуулах мэдээллийн тоо	Байршуулсан тэдээлийн тоо	Хувь	Байршуулах мэдээллийн тоо	Байршуулсан тэдээлийн тоо	Хувь
1	Архангай		49	100.0		39	100.0		61	100.0		149	100.0
2	Баян-Өлгий		47	95.92		38	97.43		60	98.36		145	97.31
3	Баянхонгор		47	95.92		39	100.0		60	98.36		146	97.99
4	Булган		49	100.0		38	97.43		61	100.0		148	99.33
5	Говь-Алтай		46	93.88		39	100.0		58	95.08		143	95.97
6	Дорнод		45	91.84		39	100.0		61	100.0		145	97.32
7	Дорноговь		48	97.96		38	97.43		61	100.0		147	98.66
8	Дундговь		42	85.71		27	69.23		57	93.44		126	84.56
9	Завхан		49	100.0		39	100.0		61	100.0		149	100.0
10	Өвөрхангай		46	93.88		26	66.67		59	96.72		131	87.92
11	Өмнөговь		48	98.01		36	92.32		59	96.72		143	96.00
12	Цогт цэций		44	89.81		27	69.23		58	95.13		129	86.65
13	Сүхбаатар		49	100.0		39	100.0		61	100.0		149	100.0
14	Сэлэнгэ	49	49	100.0	39	38	97.44	61	61	100.0	149	148	99.15
15	Төв		49	100.0		39	100.0		61	100.0		149	100.0
16	Увс		49	100.0		39	100.0		61	100.0		149	100.0
17	Ховд		48	97.96		39	100.0		61	100.0		148	99.33
18	Хөвсгөл		49	100.0		39	100.0		61	100.0		149	100.0
19	Хэнтий		49	100.0		39	100.0		61	100.0		149	100.0
20	Дархан-Уул		39	79.59		38	97.44		61	100.0		138	92.34
21	Орхон		45	91.82		37	94.92		61	100.0		143	96.03
22	УТОХГ		46	93.87		37	94.87		57	93.44		140	93.95
23	НТГ		37	75.51		39	100.0		61	100.0		137	91.84
24	Хан-Уул		49	100.0		39	100.0		48	78.69		136	91.28
25	Баянзүрх дүүрэг		34	69.41		33	84.62		59	96.72		126	60.45
26	Сүхбаатар		43	87.76		35	89.74		60	98.36		138	92.62

	дүүрэг									
27	Баянгол дүүрэг	45	91.84	38	97.44	61	100.0	144	96.42	
28	Багануур	46	93.92	37	94.93	61	100.0	144	96.61	
29	Налайх	47	95.92	39	100.0	61	100.0	147	98.72	
30	Говьсүмбэр	46	93.88	26	66.67	59	96.72	131	87.92	
31	Сонгинохайрхан дүүрэг	41	83.67	34	87.18	56	91.85	131	87.55	
32	Чингэлтэй дүүрэг	44	89.79	38	97.43	58	95.08	140	93.96	
33	ТЕГ	47	95.91	27	69.23	42	68.85	116	77.85	
Нийт			93.45		92.77		96.77		93.87	

Тайлбар: Засгийн Газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 2 дугаар бүлэгт шилэн данс нь 3 дэд цэстэй нийт 29 мэдээлэлтэй байхаар заасан боловч Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагуудын оруулах мэдээлэл нь 3 дэд цэсний 20 мэдээлэл тавигдахаар байна. Тус 20 мэдээллүүдийг сар, улирал, хагас болон бүтэн жилээр байршуулахад давхардсан тоогоор 149 мэдээлэл байх ёстойгоос татварын албад дунджаар 137-г оруулсан буюу нийт мэдээллийг 93.87 хувьтай байршуулсан байна.

Архангай, Завхан,Төв, Увс, Хөвсгөл, Хэнтий аймгийн татварын хэлтсүүд жил, улирал, сарын мэдээллийг 100 хувь оруулсан байна.

Шилэн дансны 20 төрлийн мэдээллээс татварын албанд хамааралгүй мэдээллүүдийг “байхгүй” гэж тэмдэглэж, илгээгээгүйгээс зарим аймаг, дүүргийн татварын албад мэдээллээ бүрэн оруулаагүй мэт харагдаж байна.

Шилэн дансны системд татварын албадын тайланг хугацаандаа илгээсэн байдал

/Хүснэгт-2/

д/д	Татварын алба	Төсөв гүйцэтгэл		Хөрөнгө оруулалт		Бусад		Нийт			
		Хугацаандаа байршуулсан мэдээллийн тоо	Хоцроож байршуулсан мэдээллийн тоо	Хугацаандаа байршуулсан мэдээллийн тоо	Хоцроож байршуулсан мэдээллийн тоо	Хугацаандаа байршуулсан мэдээллийн тоо	Хоцроож байршуулсан мэдээллийн тоо	Хугацаандаа байршуулсан мэдээллийн тоо	Хоцроож байршуулсан мэдээллийн тоо	Байршуулсан тэдээллийн тоо	Хоцроож байршуулсан мэдээллийн хувь
1	Архангай	40	9	31	8	50	11	121	28	149	18.79
2	Баян-Өлгий	28	21	22	16	38	22	86	59	145	40.69
3	Баянхонгор	33	14	24	15	41	19	98	48	146	32.88
4	Булган	37	12	25	13	43	18	105	43	148	29.05
5	Говь-Алтай	35	11	29	10	40	18	104	39	143	27.27
6	Дорнод	18	27	12	27	26	35	56	89	145	61.38
7	Дорноговь	34	14	31	7	46	15	111	36	147	24.49
8	Дундговь	21	21	14	13	24	33	59	67	126	53.17
9	Завхан	49	10	39	12	51	36	91	58	149	38.9
10	Өвөрхангай	34	12	13	13	51	8	98	33	131	25.19

11	Өмнөговь	24	22	27	9	41	18	92	49	141	34.82
12	Цогт цэций	26	18	21	5	49	9	96	32	128	25.12
13	Сүхбаатар	44	5	34	5	51	10	129	20	149	13.43
14	Сэлэнгэ	44	5	34	5	51	10	129	20	149	13.49
15	Төв	46	3	37	2	59	2	142	7	149	4.70
16	Увс	37	12	27	12	44	17	108	41	149	27.52
17	Ховд	39	9	26	13	44	17	109	39	148	26.35
18	Хөвсгөл	39	10	33	6	52	9	124	25	149	16.78
19	Хэнтий	38	11	33	6	46	15	117	32	149	21.52
20	Дархан-Уул	44	5	34	4	51	11	129	20	149	13.42
21	Орхон	26	19	24	13	37	24	87	56	143	39.22
22	УТОХГ	3	43	2	35	1	56	6	134		89.93
23	НТГ	10	27	32	7	6	55	48	89	137	64.91
24	Хан-Уул	29	20	16	23	19	29	64	72	136	52.94
25	Баянзүрх дүүрэг	12	22	34	4	54	7	100	39	139	28.0
26	Сүхбаатар дүүрэг	19	24	14	21	20	40	53	85	138	61.59
27	Баянгол дүүрэг	31	14	12	26	20	41	63	81	144	56.35
28	Багануур	33	13	29	8	38	23	100	44	144	30.63
29	Налайх	23	24	9	30	12	49	44	103	147	70.15
30	Говьсүмбэр	38	8	23	3	51	8	112	19	131	14.50
31	Сонгинохайрхан	16	25	16	18	25	36	57	79	136	58.10
32	Чингэлтэй дүүрэг	35	9	31	7	47	11	113	27	140	19.29
33	ТЕГ	23	23	12	16	19	23	54	62	116	53.44
Нийт дундаж											35.98

Тайлбар: Татварын албад шилэн дансны цахим хуудсанд мэдээ, тайланг 35.98 хувийн хоцролттой илгээсэн байна.

Журамд заасан хугацаанаас хамгийн их мэдээлэл хоцроож илгээсэн УТОХГ 89.93 хувь, Сүхбаатар дүүрэг 61.59 хувь, Налайх 70.1 хувь байгаа бөгөөд хамгийн бага мэдээлэл хоцрогдолтой Төв аймгийн татварын хэлтэс 4.7 хувь байна.

Татварын албад шилэн дансны нэгдсэн системд хандах “Байгууллагын админ хэрэглэгчийн эрх”, “Мэдээлэл оруулах хэрэглэгчийн эрх”-ээ бүрэн авч, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу байршуулжээ.

Дотоод аудитаар Шилэн дансны тухай хууль, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “Шилэн дансны тухай хууль”-ийн “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” заалтыг хангаж ажиллах, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасан маягтын дагуу тогтоосон хугацаанд нь мэдээ, тайланг байршуулж, илгээж хэвших зэрэг зөвлөмжүүдийг өгч, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг анхаарууллаа.

Татварын ерөнхий газрын Дотоод аудитын газар